

# ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААН ДАХЬ ЦӨМИЙН ЗЭВСГИЙН ХҮЧИН ЗҮЙЛ

*Саналлхүндэвийн Баясгалан\**

**Abstract:** Although most people think nuclear weapons were created after World War II, scientist of Germany and Japan already knew about fusion matter and something with extraordinary power. Germany and Japan, along with other powers, conducted secret projects to create an unknown weapon of mass destruction. The goal of Germany and Japan was to defeat their enemy with one weapon. Still in 1945, when the U.S. conducted its first nuclear test in Alamogordo, New Mexico, world did not know about a weapon with brutal force. Only after the U.S. dropped nuclear bombs on Japan's cities of Hiroshima and Nagasaki was the world stunned by the power of nuclear weapons. However, at that time, powers were not scared of nuclear weapons; some of them saw it as a guarantor of their security, and others saw it as an opportunity to strengthen their power and position on the world stage.

This paper covers topics such as the history of creation of the nuclear bomb, its role in international relations and international security, world powers' rivalry to gain nuclear technology and the arms race, and how nuclear weapons have shaped world politics.

**Keywords:** International Relations, International Security, nuclear weapons, Cold War, nuclear weapon treaties.

## **Оршил**

Монгол Улс цөмийн зэвсэггүй бүс болох шаардлага байгаа эсэх, түүний ач холбогдлын талаар ойлголттой болохын тулд эхлээд Дэлхийн II дайны дараа ялагч улс орнууд цөмийн зэвсгээр хөөцөлдөх болсон шалтгааныг олж тогтоох хэрэгтэй. Мөн цөмийн зэвсэг бий болсон шалтгаан, түүний олон улсын харилцаанд гүйцэтгэж буй үүргийг тайлбарлах шаардлагатай юм.

Цөмийн технологи боловсруулах асуудал хүмүүсийн бодож байгаагаас харьцангуй эрт Дэлхийн II дайны үед АНУ, ЗХУ төдийгүй Германд идэвхтэй судалгаа хийж байсан байдаг. Хэдийгээр АНУ, ЗХУ холбоотон гүрний хувьд Дэлхийн II дайнд ялагч болон хамтдаа гарч ирсэн ч цаанаа гүн зөрчилдөөнтэй байв. Ер нь цөмийн зэвсэгтэй байгаа эсэхээс үл хамааран хоёр гүрэн хоорондоо өрсөлдөж байв. Энэ өрсөлдөөн нь ганцхан цөмийн технологийн тал дээр ч бус мөн пуужингийн салбарт ч гэсэн явагдаж байв. Пуужингийн салбарт өрсөлдөөн нь 1957 онд ЗХУ анхны пуужин хөөргөснөөр “ялсныг” бид мэддэг билээ.

Пуужингийн салбартай харьцуулахад цөмийн технологийн салбар нэлээд эрчтэй явагдаж байсан юм. АНУ-ын Ерөнхийлөгч Ф.Рузвельтийн үед АНУ Манхетен хэмээх нууц төсөл боловсруулж байсан ба үүнд “хэрвээ бид өөрсдийгөө цөмийн бөмбөгийн бай болгомооргүй л байгаа бол ЗХУ-аас түрүүлж цөмийн бөмбөгтэй болох хэрэгтэй” хэмээн үзэж Манхетен төслийг яаруулж байсан талаарх түүхэн баримтууд олон байдаг. Тухайн үед АНУ ч тэр ЗХУ ч тэр, ер нь их гүрнүүд цөмийн энергийн хүчин чадлын талаар ямар нэгэн зүйл сонссон байсан боловч хэр хүчин чадалтай болох талаар төдийлөн ойлголттой байгаагүй юм.

Бусад технологийн хөгжил байсан ч Дэлхийн II дайн ид явж байсан үед цөмийн зэвсгийн асуудал улс гүрний аюулгүй байдалтай холбогдон тавигдаж байсан учраас АНУ-ын анхааралд түлхүү байсан ба цаг хугацааны хувьд ч шахуу байснаас хэрэгжилтийн үйл явц илүү хурдан байв. Үүнийг дурьдаж байгаагийн учир нь цөмийн технологийн асуудал болон цөмийн туршилт нь эхэлж бий болохдоо энхийн зорилгоор гэхээсээ илүү аюулгүй байдалтай холбоотойгоор үүссэнийг хэлэх нь зүйтэй. Сүүлд пуужингийн технологи гарснаар пуужин цөмийн цэнэгт

---

\* МУИС-ийн УТСОУХНУС-ийн дэд проф. др.  
Email: [sanbayasgalan@gmail.com](mailto:sanbayasgalan@gmail.com) ORCID: 0000-0003-0300-750X

хошууг зөөх зорилгоор бий болсон байдаг, ингэхдээ цөмийн материалыг энхийн зорилгоор ашиглах асуудал тухайн үед яригдаж байгаагүй бөгөөд АНУ ганцаараа цөмийн зэвсэгтэй болсныхоо дараа цөмийн зэвсэг бусад оронд, тэр дундаа ЗХУ-ын гарт орох вий гэдгээс болгоомжилж байсан юм. Ийм учраас цөмийн зэвсгийн тархалтаас урьдчилан сэргийлэхийн тулд энхийн зорилгоор цөмийн технологийг ашиглахад хамтран ажиллах, энэ талын асуудлыг ОУБ-д хариуцуулах зэрэг олон арга зам эрэлхийлж байсан байна.

### ***Цөмийн зэвсгийн хөгжлийн түүх***

Анх 1945 оны 6-р сарын 16-нд АНУ Нью Мехико мужийн Аламогордод цөмийн туршилт хийсний дараа л аль хэр хүчтэй зэвсэгтэй болсноо сая ойлгосон АНУ 1945 оны 8 сард Японы Хирошима, Нагасаки хотуудад цөмийн бөмбөг хаяснаар цөмийн эрин үе эхэлсэн гэж үздэг. Үүний зэрэгцээ дэлхий дахинаа цөмийн зэвсэг ямар хүчтэй болох, дайны явцыг хэрхэн эргүүлэх чадвартай болохыг Японд болсон үйл явдал тод харуулсан юм.

Дэлхийн II дайны үед их гүрнүүдэд цөмийн зэвсгийн талаарх төсөөлөл зөвхөн АНУ, ЗХУ-аар зогсохгүй бусад оронд, тухайлбал Япончуудад ч гэсэн байсан олон баримт байдаг. Хирошима дахь цөмийн бөмбөг дэлбэрсэн газар Японы цөмийн мэргэжилтнүүд очиж судалгаа хийхэд түүнд агуулагдаж байсан элемент нь U-235 байсныг олж тогтоон АНУ ураны цөмийн бөмбөгтэй юм байна гэхдээ ганцхан ширхэг<sup>1\*</sup> л байх боломжтой гэж зөв дүгнэсэн байдаг (Reed, 2010, p. 23). Хэдийгээр АНУ цөмийн бөмбөг хаясан ч Японы засгийн газар бууж өгөх бодолгүй байсан нь тухайн үеийн цэргийн эрхтнүүдийн байр сууринаас харагддаг билээ. Тэдний гол зорилго нь сүүлчийн хүнээ хүртэл тулалдах эрс шийдэмгий байр суурьтай байв. Ийм ч учраас тэд АНУ-ын тэнгисийн флотын эсрэг амиа золиослогчдыг (камиказе) явуулдаг байсан. Харин дараагийн бөмбөг Нагасаки хотод дэлбэрсний дараа Японы цөмийн мэргэжилтнүүд газар дээр нь очиж шинжилгээ хийхэд энэ удаагийн бөмбөг Хирошимад хаясан бөмбөгнөөс арай өөр элемент илрүүлсэн ба чухамдаа плутони агуулсан болохыг тогтоов<sup>2\*\*</sup>. Иймээс Япончууд АНУ-д плутони агуулсан цөмийн зэвсэг байна гэдэг нь нэг биш нэлээд олон тооны ийм бөмбөг байх учиртай гэсэн дүгнэлтэнд хүрсэн байдаг. Иймээс япончууд АНУ-д цөмийн өөр зэвсэг байгаа гэдгийг тооцон үзэж бууж өгөх хэрэгтэй гэсэн дүгнэлтэнд хүрсэн байдаг. (Reed, 2010, p. 23) Ийм учраас хэдийгээр Японы цэргийн эрхтнүүд бууж өгөх бодолгүй байсан ч хоёр хотууддаа цөмийн зэвсэг “туршуулсан” Японы засгийн газар хэрэв АНУ дахин ийм бөмбөг хаявал япончууд сүйрэхийг ойлгож милитарист Японы засгийн газрын цаашдын үйл ажиллагааг тасалдуулахын тулд Японы эзэн хаан түүхэндээ анх удаа радиогоор ард түмэндээ төдийгүй АНУ-д хандан үг дуугүй бууж өгч байгаагаа албан ёсоор зарласан байдаг.

Японы Хирошима, Нагасаки хотуудад АНУ-ын хаясан цөмийн бөмбөг АНУ-ын хувьд нэг ёсны туршилт болж, Японыг үг дуугүй бууж өгөхөд хүргэсэн төдийгүй дэлхий дахинд үй олноор хөнөөх өндөр хүчин чадалтай зэвсэг бий болсныг харуулав. Дэлхий дахин цөмийн зэвсгийн хор хөнөөлийн хэмжээг мэдэх болж, өнөөг хүртэл цөмийн бөмбөгийн хүчин чадлыг Хирошима, Нагасакид хаясан бөмбөгний хүчин чадалтай харьцуулан хэлдэг билээ. Японы Хирошимад хаясан цөмийн бөмбөг хүн төрөлхтөн урьд нь ямар ч дайнд үзэж байгаагүй үр дагаврыг үзүүлснээрээ дэлхий дахиныг цочролд оруулсан юм.<sup>3</sup> Цөмийн зэвсгийг их хэмжээгээр хийх боломжтой болсон нь цаашдын тархалтын үндэс болов.

<sup>1\*</sup> Ураны материалаас U-235-ыг гарган авахад аврага том дэд бүтэц хэрэгтэй болохыг Японы эрдэмтэд мэдэж байсан, энэ утгаараа ч асар их хэмжээний зардал гарах байв.

<sup>2\*\*</sup> Япончууд АНУ плутони гарган авах тогоотой гэсэн дүгнэлтэнд хүрсэн байдаг.

<sup>3</sup> Цөмийн дэлбэрэлт нь энгийн бөмбөгний дэлбэрэлтээс 100 бүр 1000 дахин хүчтэй юм. Эдгээр зэвсгүүд нь дэлбэрэлтийн хүч буюу устгах долгион ялгаруулдаг. Энгийн болон цөмийн зэвсэглэлийн ялгаа нь цөмийн зэвсэг аль

АНУ-ын хаясан бөмбөг түүний өрсөлдөгч ЗХУ-ыг ийм төрлийн зэвсэгтэй болох хэрэгтэй юм байна гэсэн бодолд хүргэв. Үүний өмнө АНУ-ын цөмийн хөтөлбөрийн талаар мэдэж байсан И.Сталинд АНУ-ын тал 1945 онд болсон Ялтын бага хурлын үеэр цөмийн туршилт хийсэн талаараа дуулгахад тэрээр цөмийн бөмбөгийн ач холбогдлыг үл тоон “Цөмийн бөмбөг бол хулчгар хүмүүсийг айлгахад зориулагдсан болохоос бус дайны үйл явцыг эргүүлж чадахгүй. Цөмийн бөмбөг үүнд хангалтгүй” гэж хэлж байсан (Д.Цолмон, 2009, хууд. 54). Харин Хирошима, Нагасаки хотуудад болсон үйл явдлын дараа тэрээр “Бид ийм зэвсэгтэй болох хэрэгтэй” гэж хэлсэн удаатай (Reed, 2010, p. 29). Тиймээс ЗХУ-ын хувьд цөмийн бөмбөгтэй болохын тулд АНУ-аас цөмийн технологийн тагнуулыг маш эрчимтэй хийж ирсэн түүх бий. Үүнээс хойш улс орнууд цөмийн зэвсэг хэчнээн аюултай болохыг мэдэх болж, ийм зэвсэгтэй болохыг эрмэлзэх болсноор “цөмийн хувьсгал” эхлэв (Cold War Statesmen Confront the Bomb: Nuclear Diplomacy since 1945, 1999).

Тухайн үед цөмийн зэвсэгийг эзэмшдэг ганц улс нь АНУ байсан тул цөмийн зэвсэгтээ дулдуйдсан гадаад бодлого болох “цөмийн дипломат бодлого” (nuclear diplomacy) явуулах болж, цөмийн дангаар ноёлох (монополизм) байдлаа алдахгүйн тулд бусад улс орон ялангуяа гол дайсан ЗХУ цөмийн зэвсэгтэй болохоос урьдчилан сэргийлэх, ЗХУ-ыг тогтоон барихад оршиж байв. Энэ үед АНУ-д ЗХУ-ыг түрүүлж дайрах уу (pre-emptive strike) эсвэл айлган сүрдүүлэх үү (deterrence) гэсэн асуулт гарч байв.

1946 онд “Хүйтэн дайн” хэмээх ойлголт үүсэж байх үед АНУ цөмийн зэвсэгтэй болсон, мөн АНУ, ЗХУ хоёр үзэл суртлын зөрчилтэй байв. АНУ цөмийн зэвсэгтээ дулдуйдаж, коммунизмыг тогтоон барих бодлого явуулж байсан нь ЗХУ-ын хилд аль болох ойр, өөрийн зэвсгийг байрлуулахыг бодож байв. Ингээд 1948 онд Берлиныг бүслэн хаасан байсан үед АНУ цөмийн бөмбөгдөгч В-29 онгоцуудаа Их Британид байрлуулсан байв. Их Британи ч гэсэн АНУ-ын хамгаалалтанд аюулгүй байна гэж бодож байв.

Тухайн үед АНУ ЗХУ-ыг цөмийн зэвсгээ дор хаяж арван жилийн дараа туршина гэж тооцоолж байсан (Reed, 2010) боловч 1949 оны 8 сарын 29-нд ЗХУ цөмийн зэвсэгтэй болсноор хоёр туйл болон сөргөлдөж байсан хоёр их гүрний хүч тэнцэж, АНУ-ын цөмийн монополизм байдалд төгсгөл ирэв (Reed, 2010, p. 34). Үзэл суртлын хоёр лагерт хуваагдсан байсан АНУ, ЗХУ нэгэнт хоёулаа цөмийн зэвсэгтэй болж, хүч тэнцсэн байсан учраас өөрсдийн аюулгүй байдлыг хангах, нэг нь нөгөөгөөсөө илүү давамгайл байдлыг олж авахын тулд цөмийн зэвсэглэлээр хөөцөлдөж, бие биенийхээ эсрэг цөмийн зэвсэг онилох болов. ЗХУ цөмийн туршилт хийсний дараа АНУ-ын Ерөнхийлөгч Х.Труман “бид цөмийн бөмбөгийг хийж чадалгүй нэг жил эсвэл жил хагасаар л хоцорсон бол өөрсөд дээрээ туршилт хийлгэх ч байсан байж магадгүй юм” (Д.Цолмон, 2009, хууд. 55) хэмээн хэлсэн нь АНУ цөмийн монополизм байдлаа удаан хадгалж чадаагүйтэй холбоотой, мөн цөмийн зэвсгийн хүч чадлыг ойлгож байсныг харуулдаг (Reed, 2010).

Хэдийгээр зарим талаар хүйтэн дайн үзэл суртлын дайн байсан ч түүний цаана геополитикийн ашиг сонирхол явж байсныг Хүйтэн дайны үед хоёр туйлын гол төлөөлөгч орнууд болох АНУ, ЗХУ-ын хооронд болсон Карибын хямрал тод харуулж өгсөн. Тэд бие

---

ч энгийн зэвсэгт байдаггүй тийм их дулааныг ялгаруулдаг ба энэхүү дулаан нь хурц гэрэл, өндөр халуун ялгаруулдаг, үүнийг нь термал энерги ч гэж нэрлэдэг. Энэ энерги арьс түлэх болон дэлбэрэлт болсон газраас хол байгаа газарт гал тавих үндэстэй. Ингээд зогсохгүй янз бүрийн төрлийн радиац ялгаруулдаг. Эдгээр нь хэдхэн секундээс нэлээд удаан хугацаагаар үргэлжлэх боломжтой. Цөмийн зэвсгийн энергийн 85% орчим нь агаарын дэлбэрэлт буюу шок байдаг. үлдсэн 15% нь цөмийн янз бүрийн радиац хэлбэрээр гардаг. 5% нь анхдагч цөмийн радиац байдаг. Эдгээр нь голчлон гамма долгион болон нейтонууд байдаг.

биерүүгээ шууд зэвсэглэн дайраагүй, гагцхүү үзэл суртлаар бие биенийгээ үгүйсгэж байсан. Үүний гол шалтгаан нь тус хоёр улс цөмийн зэвсгээр дайтах тохиолдолд хоёулаа хохирно гэдгийг сайн ойлгож байв. Энэ үүднээсээ ч тэр АНУ, ЗХУ аюулгүй байдлаа бэхжүүлэхийн тулд бие биенээсээ давах шаардлагатай болсон байна. Зэвсгийн хүчээр тэнцүү хоёр улс бие биенээсээ давамгайл байх ганц арга нь цөмийн зэвсгийн босоо болон хэвтээ тархалт байв. Босоо тархалт гэдэгт цөмийн зэвсэгтэй орнууд цөмийн зэвсгийн тоо болон тэдгээрийг тээгч технологийг боловсронгуй болгохыг ойлгодог (үүнд цөмийн зэвсгийг газрын гүнээс, газраас, агаараас, усан онгоцноос, усан доороос харвах төхөөрөмж ордог). Хэвтээ тархалт гэдэгт цөмийн зэвсэгтэй орон цөмийн зэвсгээ нутаг дэвсгэрийнхээ гадна, газар зүйн ашигтай байршилтай нутаг дэвсгэр дээр байрлуулахыг ойлгодог (үүнд сансарын орон зай, далай, мөн бусад орнуудтай эвсэл байгуулснаар тухайн улсын нутаг дэвсгэр дээр байрлуулах).

Товч дүгнэхэд Японы Хирошима, Нагасаки хотуудад хаясан цөмийн бөмбөгийн үй олноор хөнөөх чадвар бусад улс орнуудыг ийм зэвсэгтэй болох эрмэлзлэлийг бий болгосон нь цөмийн зэвсэглэлээр хөөцөлдөх (arms race) эхлэлийг тавив.

### ***Цөмийн зэвсгээр хөөцөлдөж эхэлсэн нь***

Хоёр гүрэн нэгэнт цөмийн зэвсэгтэй болсон учраас бие биенээсээ давахын тулд цөмийн туршилтуудыг ар араас нь хийж ирсэн ба цөмийн зэвсгээ аль болох дайсныхаа нутаг дэвсгэрт ойр байлгах асуудал гарч ирсэн нь бусад улс орны аюулгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг шууд хөндөх болов. Монгол Улс ч гэсэн энэхүү үйл явцын гадна үлдээгүй, ЗХУ-ын холбоотны хүрээнд аюулгүй байдлаа хангуулж байв. Цөмийн зэвсгийн өрсөлдөөн хүрээнээсээ халин гарч бусад орнууд ч гэсэн аюулгүй байдлаа хангахад цөмийн зэвсэг хэрэгтэй юм байна гэсэн ойлголттой болов. Энэ нь цөмийн зэвсэггүй, тийм боломж байхгүй орнуудын аюулгүй байдал, оршин тогтнох асуудалд аюул учруулах болов.

Үүн дээр дөрөөлөн цөмийн зэвсэг хийх боломжтой улс орнууд цөмийн зэвсгээр хөөцөлдөж, аюулгүй байдлаа хангахын зэрэгцээ дэлхийн тавцанд нэр нөлөөгөө бэхжүүлэх гол хэрэгслийн нэг гэж үзэх болсон байна. Ялангуяа Их Британи хоёр гүрний зөрчилд нэрвэгдэх магадлалтай гэж үзэж, мөн хуучин хүчирхэг байсан орнуудын хувьд Их Британи, Франц зэрэг орнууд цөмийн зэвсэгтэй болвол олон улсын тавцанд дахин байр сууриа эзлэхэд цөмийн зэвсэг хэрэгтэй гэж үзэж байв. Мэдээж иймэрхүү байдал нь цөмийн зэвсэгтэй болох боломжгүй болон Япон шиг өөр дээрээ цөмийн зэвсэг “туршуулсан” орнуудын аюулгүй байдлын асуудал аяндаа тулгараад ирнэ.

ЗХУ-д хамгийн ойр орших АНУ-ын холбоотон улс нь Их Британи байв. Их Британи аюулгүй байдал нь найдвартай хамгаалагдаж байна гэж ойлгож байсан боловч 1949 онд ЗХУ цөмийн зэвсэг амжилттай туршсан нь түүний санааг зовоох болов. Учир нь Британий нутаг дээр байгаа АНУ-ын онгоцуудыг Британичууд ашиглах эрхгүй байсан<sup>4\*</sup> ба АНУ ЗХУ-ыг Английн нутаг руу дайрна гэж айлгүйгээр ЗХУ руу дайрах тохиолдолд хариу цохилт Их Британи дахь АНУ-ын цэргийн бааз болох байв (Reed, 2010, p. 49). Өөрөөр хэлбэл Их Британи улс цөмийн цохилтонд өртөж хоёр гүрний сөргөлдөөнд хохирч болзошгүй байв. Энэ бүгдээс болгоомжилсон Британичууд эхлээд АНУ-ын цөмийн зэвсгийг хамтран эзэмших талаар санал гаргасан боловч АНУ зөвшөөрөөгүй юм. Их Британий аюулгүй байдалд аюул учирч байсан учраас Ерөнхий сайд У.Черчилль АНУ-ыг ЗХУ-ын эсрэг цөмийн зэвсэг хэрэглэхийг хүртэл хүсэж байв. Үүсээд байгаа

---

<sup>4\*</sup> АНУ-ын хувьд Баруун Европ болон АНД-д орших холбоотон орнууддаа байрлуулсан байсан цөмийн зэвсэг болон стратегийн зэвсэглэлийг тухайн оронд захирах эрхийг олгодоггүй байсан.

нөхцөл байдлаас үүдэн Британичууд өөрсдөө цөмийн хөтөлбөр хэрэгжүүлж эхлэв. Ингээд Их Британи 1952 оны 10 сарын 3-нд анхны цөмийн туршилтаа Австралийн Монте Белло аралд хийснээр дэлхийд АНУ, ЗХУ-ын дараа гурав дахь цөмийн зэвсэгтэй улс болов. Нөхцөл байдал ийнхүү өрнөж байгаа нь цөмийн зэвсгийн асуудал хяналтнаас гарч цаашид олон орон цөмийн зэвсэгтэй болох аюул бодитоор бий болов.

1954 оны 2 сард АНУ<sup>5+</sup> ус төрөгчийн бөмбөгийн туршилтыг Номхон далайд явуулах болсноо зарласан. Энэхүү үйл явдлаас үүдэн, Их Британи мөн ийм төрлийн зэвсэг эзэмшиж байж олон улсын харилцаанд байр сууриа хадгалах ба ЗХУ-аас ирэх аливаа цохилтоос хамгаалах зорилгоор 1954 оны 7 сарын 27-нд ус төрөгчийн бөмбөг туршихаар болов (Reed, 2010). Энэ хооронд ЗХУ 1955 оны 11 сард Семипалатинскд “RDS-37” ус төрөгчийн бөмбөг болох “Царь бомба”-г туршив. 1957 оны сүүл гэхэд цөмийн туршилтыг болиулах олон улсын шахалт ихсэж ус төрөгчийн бөмбөгийг агаарт туршихаа болив. Энэ хооронд Их Британи Австрали орчмын арал болох Монте Белло, Номхон далай дахь Христмасын арал болон Маралингад өөрийн цөмийн туршилтаа үргэлжлүүлсээр байв (Arnold, 2001). Хэмжээ хязгаараа алдаад байсан цөмийн туршилтыг хязгаарлах шаардлагатайг гурван гүрэн ойлгож байсан ч бодит байдал дээр туршилтаа үргэлжлүүлсээр байв.

1958 оны 7-р сарын 1-нээс 8-р сарын 21-ний хооронд 8 улсын мэргэжилтнүүд нэгдэн Женев хотноо газар доорх цөмийн туршилтыг хэрхэн тодорхойлох талаар хэлэлцэж, тодорхойлох байгууллагыг нь Олон улсын атомын энергийн агентлаг (ОУАЭА) гэж үзэв. Энэ байгууллага туршилтанд хяналт тавих боломжтой цөмийн асуудлыг хариуцсан цорын ганц байгууллага байв. Гэвч АНУ болон барууны орнууд ОУАЭА-гийг цөмийн туршилтыг хянах хорих гэж байгуулагдаагүй гагцхүү энхийн зорилгоор ашиглахад үйл ажиллагаагаа явуулах ёстой гэсэн байр суурьтай байв. Иймд цөмийн туршилтыг хориглох гэрээний байгууллага байгуулж, энэ нь ОУАЭА-тай төстэй үйл ажиллагаа явуулах болов (Fisher, 1999, p. 82). Үүнтэй холбогдуулан АНУ өөрийн зүгээс тодорхой алхам хийхээр шийдэж 1958 оны 6 сарын 30-нд МакМахоны хууль<sup>6\*</sup> санаачлан цөмийн зэвсэгтэй бусад орнуудтай цөмийн бус материалыг харилцан солилцож байхаар болов. Олон тооны цөмийн туршилт хийчихээд байсан АНУ, ЗХУ, Их Британи харилцан итгэлцлийн зарчим дээр 1958 оны 11 сарын 1-нд цөмийн туршилтыг хориглох тухай гурван талын хяналтгүй<sup>7\*</sup> мораторийг батлав (Reed, 2010, p. 62). Ингэснээр цөмийн туршилтыг зогсоож чадна гэж найдаж байв. Уг мораторигаар АНУ, Их Британи улсууд цөмийн туршилтын байгууламжуудаа хааж, цөмийн зэвсгийн зарим үйл ажиллагаагаа зогсоохоор болсон байна. Энэхүү моратори сайн дурынх байсан учраас үүнийг хянах бүтэц байгаагүйгээрээ онцлог юм. Харамсалтай нь энэхүү моратори цөмийн бүх туршилтыг болиулж чадаагүй, гэхдээ зогсоохыг оролдсон оролдлого байв. Энэ нь их гүрнүүдийг цөмийн аюулгүй байдлын асуудалд анхаарлаа хандуулахад хүргэж байв. Дэлхийн гурван гүрэн цөмийн туршилт явуулж байхад нэг талаар Их Британиас болгоомжилсон, нөгөө талаар АНУ, ЗХУ-ын аль нэгнийх нь нөлөөнд орохгүй хуучны их гүрний статусаа дахин гаргаж ирэхийг хүссэн Франц зүгээр хараад суусангүй. Франц улс аюулгүй байдлаа бэхжүүлэх, олон улсын тавцанд өөрийн байр сууриа хадгалах цорын ганц арга нь цөмийн зэвсэгтэй болох явдал хэмээн үзэж байв. Иймдээ ч Франц цөмийн туршилтаа 1961 оноос Алжирт газар доор туршиж эхлэв. Франц цөмийн

<sup>5+</sup> U.S Joint Committee on Atomic Energy (JCAE), уг хороо АНУ-ын Сенат болон Төлөөлөгчдийн Танхимийн гишүүдээс бүрддэг.

<sup>6\*</sup> McMahon Act гол зорилго нь цөмийн туршилт хийхгүй байх зорилгоор цөмийн холбогдолтой материалуудыг харилцан солилцох байв

<sup>7\*</sup> хяналтгүй гэдэг нь цөмийн зэвсэгтэй улс орнууд сайн дураар энэхүү мораторийд нэгдэж хөндлөнгийн хяналт эсвэл хүлээсэн үүргээ биелүүлж байгаа эсэхийг шалгах аливаа хөндлөнгийн субъектгүй болохыг ойлгоно

туршилт хийснээр дөрөв дэх цөмийн гүрэн болов. Франц цөмийн туршилт хийсэнтэй холбогдуулан 1961 оны 9-р сарын 1-нд Н.Хрушев мораторигаас сайн дураар татгалзаж байгаагаа мэдэгдэн агаарын туршилтаа сэргээсэн байдаг. ЗХУ пуужингийн дайралтаас хамгаалах шинэ тогтолцоог бий болгох зорилготой байв. ЗХУ-ын энэхүү алхамын хариуд АНУ газар доорх туршилтаа сэргээж, мөн 1962 оны 4-11-р сард Номхон далайд агаарын туршилт хийв. Франц цөмийн туршилт хийснээр цөмийн туршилтыг хориглох моратори цөмийн зэвсэгтэй барууны орнуудын аливаа оролдлого амжилтгүй болж байв (Reed, 2010). Гэхдээ АНУ өөрийн санаачилсан мораторийг хүчин төгөлдөр хэвээр байгаа гэж үзэн Бикини, Энвенток дахь байгууламжаа дахин ашиглаагүй юм.

Дэлхийд цөмийн аюул занал ямар ойрхон байж болохыг мэдрэх хүртэл буюу 1962 оны Карибын хямрал<sup>8</sup> хүртэл их гүрнүүд цөмийн туршилтаа үргэлжлүүлсээр байв (Reed, 2010, p. 65). Карибын хямрал намжиж, цөмийн дайны аюул маш ойрхон байгааг ойлгуулсан учраас хямралын дараа, 1963 оны 8 сарын 5-нд Цөмийн туршилтыг хэсэгчилэн хориглох тухай гэрээнд (ЦТХХТГ)<sup>9</sup> АНУ, ЗХУ, Их Британи улсууд гарын үсэг зурав. Уг гэрээ хүчин төгөлдөр болсны дараа жил буюу 1964 оны 10 сарын 16-нд БНХАУ Лоб нуурт цөмийн туршилт хийснээр цөмийн зэвсэгтэй тав дахь гүрэн болов. Үүнээс хойш Хятад улс агаарын болон газар доорх туршилтаа үргэлжлүүлсээр байв (Reed, 2010, p. 66).

Хятад 1964 онд цөмийн туршилт хийсний дараа АНУ-ын Ерөнхийлөгч Л.Жонсон “цөмийн зэвсгийн тархалт хүн төрөлхтөнд аюултай... Бид үүний эсрэг ажиллах хэрэгтэй, бид цаашид ч ажилласаар байх болно” гэж хэлсэн байдаг. Л.Жонсоны хэлсэн үг цөмийн зэвсгийн тархалт асар хурдан явагдаж байгаа, цөмийн хор хөнөөлийг сайтар ойлгож байгаа ч хянаж, зогсоож чадахгүй байгааг нотолсон юм. Үүний зэрэгцээ Хятад улс цөмийн зэвсэгтэй гүрэн болсноор цөмийн туршилт болон цөмийн зэвсгийн тархалт хяналтнаас гарсныг харуулав. 1964 онд Хятад цөмийн клубт<sup>10\*</sup> орсон нь анх ус төрөгчийн бөмбөг хийх санаанаас татгалзаад байсан Францыг бодлоо өөрчлөхөд хүргэв (Reed, 2010, p. 123). Цөмийн туршилтыг хэсэгчилэн хориглох тухай гэрээг (ЦТХХТГ)<sup>11\*</sup> их гүрнүүд байгуулсныг үл харгалзан 1966 онд Франц агаарын туршилтаа үргэлжлүүлж, гадаад бодлогоо өөрчлөн НАТО-гийн үйл ажиллагаанд оролцохоос татгалзав. 1967 онд Франц цөмийн туршилтаа үргэлжлүүлж, Хятад мөн онд ус төрөгчийн бөмбөгөө туршив. Цөмийн зэвсэгтэй таван гүрэн цөмийн зэвсгээр улайран хөөцөлдөж, цөмийн туршилт хийж байсан нь хор уршиг дагуулж дэлхийн бусад улс орнууд эсэргүүцэх болов.

1962 онд Хятад, Энэтхэгийн хооронд хилийн мөргөлдөөн болж, үүнээс хойш Хятад Энэтхэгийн дайсан болох Пакистан руу анхаарлаа хандуулах болов. Энэтхэг нь Хятадтай хийсэн мөргөлдөөнөөс үүдэн цөмийн зэвсгийн хөтөлбөрөө өргөжүүлэхээр болов. Энэтхэгийн хувьд бүр 1947 онд анх тусгаар тогтнож байх тэр үед Энэтхэгийн Ерөнхий сайд Ж.Неру “Бид цөмийн энергийг дайны зорилгоос холуур хөгжүүлэх ёстой, гэхдээ хэрэв дайны зорилгоор бий болгох шаардлагатай болвол хэн ч биднийг зогсоож чадахгүй” гэж хэлж байжээ.

1967 онд Хятад ус төрөгчийн бөмбөг туршсан тэр үед Энэтхэг нууцаар цөмийн зэвсэг боловсруулж эхэлсэн ба 1968 онд Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх гэрээ (ҮДГ) байгуулагдах үед Энэтхэг уг гэрээнд нэгдэн орохоос татгалзсан төдийгүй ҮДГ хүчин төгөлдөр болоод удаагүй байхад 1974 онд цөмийн туршилтаа хийсэн байдаг. Энэтхэг цөмийн туршилтаа хийсний дараа

<sup>8</sup> ЗХУ Кабын арал дээр АНУ-ыг чиглүүлэн дунд тусгалын цөмийн цэнэгт пуужин нууцаар байрлуулсан

<sup>9</sup> Limited test ban treaty (LTBT), Partial test ban treaty (PTBT), Nuclear test ban treaty (NTBT) зэргээр нэрлэдэг, энэхүү гэрээ нь газар доорх туршилтаас бусад туршилтыг хориглосон гэрээ

<sup>10\*</sup> цөмийн зэвсэгтэй орнуудыг нийтэд нь цөмийн клуб гэж нэрлэдэг

<sup>11\*</sup> Франц тухайн үед уг гэрээнд нэгдэж ороогүй байв.

Пакистан цөмийн зэвсгийн тал дээр Хятадтай нягт харилцах болж, “миний дайсны дайсан миний найз” гэх зарчмаар ажиллах болов. Пакистан 1983 онд цөмийн туршилт хийв. Эдгээр туршилтын үр дүнд хэдийгээр цөмийн зэвсэгтэй хоёр их гүрэн зэвсэглэлээр хөөцөлдөж байсан боловч үүн дээр бусад орнууд нэмэгдэн орж, өнөөдрийн байдлаар АНУ 7315 ширхэг, ОХУ 8000 ширхэг, Их Британи 225 ширхэг, Франц 300 ширхэг, БНХАУ 250 ширхэг цөмийн цэнэгт хошуутай байна гэсэн судалгаа байгаа ба үүн дээр Энэтхэг ойролцоогоор 90-110, Пакистан 100-120, Хойд Солонгос 10 орчим, Израиль 80 орчим хооронд байж болох цөмийн цэнэгт хошуутай байж магадгүй гэсэн багцаалсан тоо байна. Энэ судалгаагаар авч үзвэл дэлхийд нийтдээ 16400 орчим цөмийн зэвсэг байна гэж үзэж болно (Kristensen, 2016).

Дээрх үйл явцаас товч дүгнэхэд 1945 онд хийсэн анхны цөмийн туршилтаас хойш улс орнууд зэвсэглэлээр хөөцөлдөх, цөмийн туршилт хийх нь огцом өссөнөөс үүдэж хүн төрөлхтөн аюултай байдалд орох эрсдэл эрс нэмэгдэж байсан учраас цөмийн зэвсэгтэй орнууд цөмийн зэвсэгт хяналт тавихыг оролдох болов.

Өнөөдөр Хойд Солонгос зэрэг цөөхөн орноос бусад нь цөмийн туршилт хийхгүй болсон харин цөмийн зэвсэгтэй орнууд цөмийн цэнэгт хошууг тээгч технологи болох пуужингийн туршилт үргэлжилсэн хэвээр байна.

Хүйтэн дайны үеийн гол хоёр гүрэн болох АНУ, ЗХУ-ууд цөмийн зэвсгээр хөөцөлдсөн явдал нь бусад улс орнуудын аюулгүй байдлыг шууд болон шууд бусаар хөндөж ирсэн ба цөмийн зэвсэгтэй улсууд зэвсгээ улам боловсронгуй болгож байгаа олон улсын харилцааны нөхцөл байдал Монгол Улсын аюулгүй байдалд ч нөлөөлж болзошгүй юм.

### ***Цөмийн зэвсэгт тавих хяналт***

АНУ ганцаараа цөмийн зэвсэгтэй байх үедээ цөмийн тархалтыг зогсоох гол арга зам нь цөмийн технологийг энхийн зорилгоор ашиглах явдал гэж үзэж байв. Нэмж хэлэхэд цөмийн зэвсэгтэй улс орнууд зэвсгийн зориулалтаар ашиглах тал дээр илүү анхаарч байснаас биш энхийн зориулалтыг анзаардаггүй байсныг дээр дурьдсан билээ.

Их гүрнүүд цөмийн зэвсгээр хөөцөлдөхөд гол зүйл нь цөмийн туршилт байсан ба зэвсгийг хязгаарлахын тулд туршилтыг зогсоох шаардлагатай байв. Харамсалтай нь цөмийн туршилтыг зогсоохыг оролдож эхлэх үед олон улс орон цөмийн зэвсэгтэй болсон байв. Цаашдаа өөр олон улс орнууд цөмийн зэвсэгтэй болох хандлагатай байсан учраас цөмийн зэвсгийг дэлгэрүүлэхгүй байхад хяналт тавих, үүний тулд хяналт тавих орчныг бүрдүүлэх хэрэгтэй байв. Энэ зорилгоор гэрээ байгуулах санаачлагыг Ирландын ГХЯ-ны сайд Франк Айкен гаргаж (Shaker, 1980, p. 3), 1958 онд НҮБ-ын ЕА-н 13-р чуулганд анх тавьжээ. Тухайн үед АНУ, ЗХУ, Их Британи гурав улс цөмийн зэвсэгтэй болчихсон байв. Ирландын талаас тавьсан энэхүү санал хоёр гол зорилготой байв. Үүнд: нэгт, цөмийн зэвсэг цаашид тархах аюул байгаа эсэхийг судлаж, ийм аюул байгаа бол ЕА-н тогтоолын төсөлд цөмийн зэвсэг эзэмшсэн орнууд нэмэгдэх аюултай байгаа, ингэснээр дэлхийн энх тайван тогтвортой байдал суларч, ОУХ-ны нөхцөл байдал түгшүүртэй болсноор зэвсэг хураахад улам хэцүү болох талаар дурьдахыг санал болгож байв (Shaker, 1980, p. 4). Хоёрт, энэхүү тогтоолыг хэлэлцэх хугацаанд цөмийн зэвсэг туршихаа зогсоож, хэлэлцээнд оролцож буй талууд цөмийн туршилт явуулахгүй байхын зэрэгцээ бусад улс орнуудыг цөмийн зэвсгээр хангахгүй байхыг уриалсан байна (Shaker, 1980, p. 4).

Ф.Айкений анхааруулж байсан аюул нь цөмийн зэвсэг эзэмшигч улс орны тоо ихсээд зогсохгүй геометрын прогрессоор өсөх аюултай байв. Хэдийгээр улс орнууд үүнийгээ ойлгож

гэрээ байгуулах хэмжээнд тун ойртож очсон ч ямар нэгэн байдлаар үр дүнд хүрдэггүй байв. Учир нь үзэл суртлаар хуваагдаж, бие биендээ үл итгэн айдас давамгайлсан бодлогоос үүдэн гаднаас ямар нэгэн аюул ирнэ хэмээн болгоомжилж байв. Үүнийг олон улсын харилцааны анархи орчинтой холбон тайлбарлаж болно.

1960-аад оноос цөмийн зэвсгийн асуудал ид хүчтэй яригдаж байв. Үүнд олон улсын харилцаанд болж байсан үйл явдлууд болох Карибын хямрал, 1960, 1964 онуудад цөмийн зэвсгийн клубт цөмийн зэвсэгтэй гурван улс дээр шинээр нэмэгдэж орсон хоёр улс, НАТО олон улсад цөмийн зэвсэгт хүчнийг байрлуулах санал гаргасан, Герман, Итали улсууд цөмийн зэвсэгтэй болох талаарх Франц, Герман, Италийн хоорондын яриа хэлэлцээ, Израиль цөмийн зэвсэгтэй болж магадгүй талаарх мэдээлэл зэрэг нөлөөлсөн байдаг (Fisher, 1999).

Харин 1962 онд АНУ-ын явуулсан агаарын туршилт болон мөн оны сүүлээр болсон Карибын хямрал цөмийн зэвсэгтэй гүрнүүдийг өөрийн эрхгүй аюулгүй байдал ба цөмийн зэвсгийн асуудалд анхаарал хандуулахад хүргэж байв. Ингээд 1963 оны 6 сарын 20-нд АНУ, ЗХУ өмнө нь төдийлөн анхаарч байгаагүй асуудлыг шийдвэрлэсэний нэг нь Цөмийн туршилтыг хэсэгчлэн хориглох гэрээ<sup>12\*</sup> байгуулахаар тохиролцов. Үүний үр дүнд АНУ, ЗХУ 1963 оны 8 сарын 5-нд Москва хотноо Цөмийн зэвсгийг агаар, сансрын уудам, усан доор туршихыг хориглох тухай гэрээ байгуулав (Reed, 2010, p. 66). Хэсэгчлэн хориглох гэрээ гэсний учир нь газар доор цөмийн туршилт хийх боломжтой хэвээр байв. Нөгөө талаар энэхүү гэрээ нь цөмийн зэвсгийн тархалтыг зогсоох бус туршилтыг л хэсэгчилэн хориглосон гэрээ болохыг санах хэрэгтэй. Гэсэн хэдий ч Франц, Хятад улсууд энэхүү гэрээнд нэгдэж ороогүй. Учир нь тэд цөмийн зэвсэг эзэмших, сайжруулах зорилгоор цөмийн туршилт хийж дуусаагүй байв. Эдгээр хүчин зүйлс нь цөмийн туршилт 1991 он буюу Хүйтэн дайн дуусах хүртэл үргэлжлэхэд нөлөөлж байв. 1993 он хүрч байж л сая нэг НҮБ-ын дэмжлэгтэйгээр Цөмийн туршилтыг бүрэн хориглох гэрээ<sup>13\*</sup> байгуулах талаар хэлэлцээ явагдаж эхэлсэн ба 1996 онд батлагдсан байдаг. Цөмийн туршилтыг хэсэгчилэн хориглох гэрээнээс ялгаатай нь бүрэн хориглох гэрээ цөмийн зэвсгийн туршилтыг бүх орчинд бүрэн хориглохоос гадна энхийн зорилготой байсан ч хориглох заалттай. Хэдийгээр 183 улс гарын үсэг зурсан боловч АНУ, БНХАУ, Израиль, Иран зэрэг улсууд соёрхон батлаагүй, Энэтхэг, Пакистан, Хойд Солонгос гэсэн цөмийн туршилт явуулж байгаа улсууд нэгдэж ороогүй байгаа учраас гэрээ хүчин төгөлдөр болоогүй хэвээр байгаа. Энэхүү гэрээ байгуулагдсаны дараа 1998 онд Энэтхэг дараа нь Пакистан, түүний дараа Хойд Солонгос 2006, 2009, 2013, 2016 онд тус тус цөмийн туршилт хийгээд байна.

Цөмийн туршилтаас гадна цөмийн зэвсгийг тээгч технологиуд асар хурдацтай хөгжин гарч ирж байсан нь цөмийн зэвсгийн тархалтын аюулыг нэмэгдүүлж байв. Тиймээс энэ асуудал цөмийн туршилтаас дутахааргүй дэлхий дахины анхаарлын төвд байгаа асуудлуудын нэг болж байна (Reed, 2010, p. 138). Мөн энэ үе эс улс орнууд өөрсдийгөө пуужингийн дайралтаас хамгаалах зорилгоор пуужингийн довтолгооноос эсэргүүцэн хамгаалах тогтолцоог байгуулж эхлэв. АНУ, ЗХУ хоёр ойрын болон дунд тусгалын цөмийн пуужингуудаа бие биендээ аль болох ойр газар байрлуулахыг эрмэлзэж байв. Хамгийн боломжит газар нь Европ тив байв. 1958 оноос АНУ Баруун Германд дунд тусгалын баллистик пуужингуудыг байрлуулсан. АНУ Туркт дунд тусгалын пуужингуудаа байрлуулж, хариуд нь ЗХУ Кубын аралд пуужингуудаа байрлуулсан нь 1962 онд Карибын хямралд хүргэснийг дээр дурьдсан билээ.

---

<sup>12\*</sup> Limited Test Ban Treaty

<sup>13\*</sup> Comprehensive Test Ban Treaty

ЗХУ АНУ-ын үйлдэлд хариу болгож Зүүн Европт дунд тусгалын пуужинг байрлуулж байв. Европт үүссэн энэхүү хурцадмал нөхцөл байдлыг түүхэнд Европуужингийн хямрал гэж нэрлэдэг билээ (Reed, 2010, p. 190). Үүнтэй холбоотойгоор 1967 онд АНУ-ын батлан хамгаалахын сайд Роберт МакНамара пуужингийн довтолгооноос хамгаалах тогтолцоо нь зэвсэглэлээр хөөцөлдөх явдлыг дэвэргэж, дайн гарах шалтаг болж болзошгүй гэдэг үндэслэлээр хориглох гэрээ байгуулахыг санал болгож байв. Цөмийн зэвсгээр удаан хөөцөлдсөн хоёр их гүрэн энэ өрсөлдөөнд ялагч байхгүй гэдгийг ойлгон 1972 онд Москва хотноо АНУ, ЗХУ хоёр пуужингийн довтолгооноос хамгаалах тогтолцооны гэрээг(ПДХТ)<sup>14</sup> байгуулж, стратегийн зэвсэглэлийг хязгаарлах талаар хэлэлцэж эхлэв.

1972 оны 5-р сарын 26-нд Москва хотноо АНУ, ЗХУ-ын хооронд баллистик пуужингийн эсрэг хэлэлцээ явуулж эхлэв. АНУ-ын Ерөнхийлөгч Р.Рэйган стратегийн зэвсгийг хязгаарлан хорогдуулах асуудлаар ЗХУ-тай хэлэлцээ хийхдээ эхлээд итгэл муутай байсан бөгөөд түүний зөвлөхүүд Зөвлөлтийн тал цөмийн дайралт эхлээд хийж болзошгүй гэж сэрэмжлүүлж байжээ (Д.Цолмон, 2007). Дараа нь Женевийн уулзалт дээр хоёр тал цөмийн цэнэгт хошууныхаа гуравны нэгийг устгах санал тавив. Үүнийг Зөвлөлтийн тал хүлээж аваагүй тул стратегийн хамгаалах санаачилга, түүнийг эсэргүүцэх цогцолбор системийн тухай төлөвлөгөөгөө баталсан юм (Д.Цолмон, 2007, хууд. 336). 1983 онд ЗХУ, АНУ дунд тусгалын пуужинг зоосноор. Европ, дэлхийн дахины байдлыг ихээхэн хурцатгасан юм. 1983 оны 3 сарын 23-нд АНУ-ын Ерөнхийлөгч Р.Рейган “Оддын дайн”-ы талаар CNN телевизэд ярилцлага өгөхдөө үүний гол ач холбогдол нь ирж буй цөмийн пуужинг газарт буухаас нь өмнө сансарт устгахад оршиж байв. Үүнийг Стратегийн хамгаалах санаачилга (СХС)<sup>15</sup> хэмээн нэрлэдэг билээ. Үүнд задардаг толгойтой пуужин<sup>16</sup> орж байгаа юм.

1984 онд АНУ Баруун Герман, Итали, Их Британид дунд тусгалын цөмийн пуужингуудыг байрлуулж эхлэв. Үүний зэрэгцээ ЗХУ-тай яриа хэлэлцээ хийх оролдлого тасраагүй хоёр тал харилцан ойлголцоход 1985 оны сүүлчээр Женевт Р.Рэйган, М.С.Горбачев нарын уулзалт болж Р.Рэйган Америкийн тал стратегийн хамгаалалтын санаачилгыг хэрэгжүүлэх эрхтэй гэж хатуухан мэдэгдэж байжээ (Д.Цолмон, 2007). 1985 онд хоёр тал Европ болон Ази дахь дунд тусгалын пуужинг хязгаарлах асуудлыг ярилцсан боловч АНУ 1989 он гэхэд Европ болон Азид байгаа бүх пуужингуудыг авч тэглэх хувилбарыг дэвшүүлсэн. Гэвч үүнд Их Британи, Францын цөмийн зэвсгийг хамруулж авч үзээгүй учраас үр дүнд хүрсэнгүй. 1986 оны 10 сарын 11-нд Рейкьявкийн дээд хэмжээний хурал болж уг хурлаар Р.Рэйган, М.С.Горбачев нар Европ дахь дунд тусгалын пуужингуудыг хоёр тал ижил 100 ширхэг болгохоор болов.<sup>17</sup> Харин дараа жилийн 10 сард Рейкьявикт болсон Америк, Зөвлөлтийн дээд хэмжээний уулзалтаар зэвсэглэлээр хөөцөлдөх явдлыг зогсоохын тулд хоёр тал алсын тусгалтай пуужингаа эхний арван жилд багтаан хорогдуулах болзлыг харилцан зөвшөөрчээ (Д.Цолмон, 2007). Зэвсэглэлээр хөөцөлдөх явдлыг зогсоох, түүнд хяналт тавихад М.С.Горбачевийн 1987 онд АНУ-д хийсэн айлчлалын үеэр цөмийн зэвсгийн асуудлаар түүхэнд тэмдэглэсэн Завсрын Гэрээг үзэглэжээ. Хоёр талын дээд хэмжээний Женевийн (1985) болон Рейкьявкийн (1986) уулзалтын дүнд Вашингтонд байгуулсан энэ гэрээ эрх зүйн нарийн тохиролцоотой баримт юм.

---

<sup>14</sup> Anti Ballistic Missile (ABM)

<sup>15</sup>Strategic Defense Initiative (SDI)

<sup>16</sup>MIRV-Multiple Independently targetable Reentry Vehicle-цөмийн цэнэгт хошуу нь задардаг тив алгасагч баллистик пуужин

<sup>17</sup> Intermediate-Range\_Nuclear\_Forces\_Treaty

1987 оны 12-р сарын 8-нд Вашингтон хотноо АНУ, ЗХУ Ойрын болон дунд тусгалын цөмийн зэвсгийг устгах тухай гэрээнд<sup>1819</sup> гарын үсэг зурснаар Першингийн төрлийн пуужинг Европоос гаргасан юм. Уг гэрээнд хоёр тал энгийн болоод цөмийн дунд тусгалын<sup>20</sup> баллистик пуужингуудыг устгахаар болсон. Гэхдээ энд гагцхүү АНУ, ЗХУ-ын суурилуулсан цөмийн пуужингуудын талаар тусгагдсан болохоос бус АНУ-ын далай дахь усан онгоц, шумбагчийн пуужин болон Их Британи, Францын цөмийн зэвсгийн талаар тусгагдаагүй нь ЗХУ-ын хувьд ашиггүйгээр зурагдсан гэрээ гэж үзэхээр байв.<sup>21</sup> Ингэснээр ЗХУ SS-20 пуужингуудаа татан авч АНУ Европт цөмийн стратегийн давамгайл байдалтай болов. Энэхүү гэрээг ЗХУ ба АНУ байгуулсан нь зэвсэг хураах талаар авсан анхны бодитой арга хэмжээ болсон.

Гэрээг хүчин төгөлдөр болсноос хойш дунд (500-5500 км) тусгалын пуужинг 18 сарын дотор устгахаар тогтсон байна. Гэрээгээр олон төрлийн хяналтын арга хэмжээг нарийн чанд явуулахаар тохиролцсон. 1996 онд гэрээ бүрэн биелсэн (М.Дүгэрсүрэн, 2001). Пуужингийн технологид хяналт тавих дэглэмийн тухай 1987 оны тохиролцоо 300 км-ээс илүү тусгалтай пуужин түгэхээс сэргийлэх зорилготой. Анх долоон улс санаачилж 1995 оны байдлаар 26 улс оролцож байгаа энэ тохиролцоо цөмийн, төдийгүй химийн, биологийн зэвсгийг хязгаарлах, хориглох дэглэмийг бататгахад чиглэж байгаад гол ач холбогдол нь оршино (М.Дүгэрсүрэн, 2001). Цөмийн зэвсгийг хорогдуулах талаар тухайн нөхцөл байдлаас үүдэн шат дараатай алхмууд авч ирсэн. Үүний хамгийн эхнийх нь цөмийн туршилтыг зогсоох байсан, дараа нь ПДХТ байсан дараагийн асуудал нь дунд тусгалын пуужин устгах байв.

Стратегийн зэвсэглэлийг хязгаарлах тухай хэлэлцээ (СЗХТХ) (SALT)<sup>22</sup> баллистик пуужин тээвэрлэгч шумбагч онгоц, болон тив алгасагч баллистик пуужингийн тоог багасгахад оршиж байв. Энэхүү гэрээ АНУ ЗХУ-ын харилцаа сайжрахад нөлөөлсөн гол хүчин зүйл юм. SALT I-ийн үргэлжилэл болох SALT II нь 1972 оноос 1979 он хүртэл явсан ба АНУ, ЗХУ стратегийн бүх төрлийн зэвсэглэлийг 2250 хүртэл бууруулахаар тохиролцсон ба энэхүү гэрээгээр цөмийн зэвсгийн үйлдвэрлэлийг багасгах тухай яригдсан. 1979 оны 6 сарын 18-нд Австрийн Вена хотноо АНУ, ЗХУ хоёр гэрээнд гарын үсэг зурав. 1980 он гэхэд ЗХУ гурван мянга гаруй SS-9, SS-18 загварын хэдэн мянган цөмийн цэнэгт хошуу тээх чадвартай пуужингуудыг эзэмшиж байсан гэж үздэг байв (Reed, 2010).

Хүйтэн дайн дууссаны дараа 1991 оны 7-р сарын 31-нд АНУ болон ЗХУ-ын зүгээс зэвсэглэлийг хязгаарлахад авч хэрэгжүүлсэн дараагийн алхам нь START I<sup>23</sup> гэрээ байгуулсан ба ЗХУ задран унасны дараа уг гэрээний хавсралтаар шинээр тусгаар тогтносон орнууд болох Белорусс, Казахстан, Украин зэрэг улсууд цөмийн зэвсгээ устгахаар болж АНУ, ОХУ тал бүртээ 6000-аас илүү цөмийн цэнэгт хошуу байрлуулахгүй байхаар тохиролцов.

START I-ийн үргэлжлэл болох START II гэрээнд АНУ, ЗХУ 1993 оны 1-р сарын 3-нд гарын үсэг зурсан боловч хүчин төгөлдөр болж чадаагүй байна. Уг гэрээнд олон хэсэг болон задрагч цэнэгт хошууг (MIRV)<sup>24\*</sup> тив алгасагч баллистик пуужинд байрлуулахгүй байхаар

<sup>18</sup> Intermediate-Range Nuclear Forces Treaty (The Treaty Between the United States of America and the Union of Soviet Socialist Republics on the Elimination of Their Intermediate-Range and Shorter-Range Missiles)

<sup>19</sup> Гэрээний дагуу 1991 оны 6 сарын 1 гэхэд нийт 2692 зэвсэг устгасан байхаар тохиролцсон бөгөөд АНУ 846, ЗХУ 1846 ширхэгээр хорогдуулахаар тохиролцсон нь АНУ-ын дипломат ялалт гэж үзэх болов.

<sup>20</sup> Энэ нь 500-5500 км-ийн тусгалтай юм.

<sup>21</sup> Intermediate-Range Nuclear Forces Treaty

<sup>22</sup> SALT (Strategic Arms Limitation Talks) буюу Стратегийн зэвсэглэлийг хязгаарлах хэлэлцээ

<sup>23</sup> START (Strategic Arms Reduction Treaty) буюу Стратегийн зэвсэглэлийг хорогдуулах гэрээ

<sup>24\*</sup> MIRV (Multiple Independently Targetable Reentry Vehicle)

тохиролцсон байсан юм. 2002 оны 6-р сарын 14-нд АНУ баллистик пуужингийн довтолгооноос хамгаалах гэрээнээс<sup>25</sup> гарсны дараа ОХУ START II гэрээнээс гарав.

START III-ийн талаарх асуудал бүр 1997 онд Хельсинк хотноо Б.Клинтон, Б.Ельцин нарын хооронд яригдаж байсан боловч бүтэлгүйтсэн байдаг. Стратегийн зэвсэглэлийг хорогдуулах талаар хийсэн өөр нэг оролдлого бол 2002 онд байгуулагдсан Москвагийн гэрээ буюу Стратегийн давшилтын зэвсэглэлийг хорогдуулах тухай гэрээ SORT<sup>26</sup> юм. энэхүү гэрээ 2003 оноос хүчин төгөлдөр болж Шинэ START байгуулагдах хүртэл буюу 2011 он хүртэл хүчинтэй байв. Энэхүү гэрээгээр хоёр тал стратегийн зэвсэглэлээ 2012 он гэхэд талыг нь устгасан байх үүрэг хүлээж байв. гэхдээ устгасан гэх баталгаа байхгүй байв. Үүний дараа Шинэ START-д<sup>27</sup> ОХУ-ын ерөнхийлөгч Д.Медведев АНУ-ын Ерөнхийлөгч Б.Обама нарын 2010 оны 4 сарын 8-нд Чехийн Праг хотноо гарын үсэг зурж, 2011 оны 2 сарын 5-нд хүчин төгөлдөр болж, хоёр талын тохиролцсон ёсоор 2021 он хүртэл хүчинтэй байв. Гэхдээ дээр хэлсэнчлэн шинэ START нь START III-ийн үргэлжлэл гэхээсээ илүү SORT-ыг залгамжилсан гэж үздэг.

2007 оны 2-р сарын 10-нд ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин дунд тусгалын пуужинг хязгаарлах гэрээ ОХУ-ын ашиг сонирхолд нийцэхгүй байгаагаа зарлаж уг гэрээнээс гарахаа мэдэгдсэн ба ОХУ-ын цэргийн командлал Орос гэрээнээс гарах эсэх нь АНУ-аас шалтгаална. Учир нь АНУ Польш болон Чехийн нутаг дээр пуужингийн довтолгооноос хамгаалах тогтолцоог байрлуулах гэж байна гэжээ.

Өнөөдөр Украины хямралаас үүдэн АНУ, ОХУ бие биенээ сөрөн зогсох болсон ба зарим судлаачдын үзэж байгаагаар Хүйтэн дайн эргэн ирж байна гэх үг цухалзуулж байна. Хэдийгээр Хүйтэн дайн өмнөх шиг хэмжээнд хүрээгүй ч цөмийн зэвсэгтэй хоёр их гүрэн цөмийн зэвсэг болон стратегийн зэвсэглэлийн тоогоо нэмэгдүүлж, олон жилийн турш зэвсэглэлийг хязгаарлах асуудал талаар болох аюултай болоод байна.

2010 оны ҮДГ-ний хяналтын бага хурлын төгсгөлийн баримт бичигт 64 зүйл бүхий “үйл ажиллагааны төлөвлөгөө”-г баталсан байдаг. Энэхүү төгсгөлийн баримт бичигт “цөмийн зэвсгийн конвенци”, “олон талт үйл ажиллагааны тус тусын арга ажиллагааг бий болгох гэрээ” зэргийг оруулсан байна. Үүнд хамгийн чухал оруулсан зүйл бол ҮДГ нь “цөмийн зэвсэггүй дэлхийг бий болгох, хадгалах шаардлагатай бүтцийг бий болгоход улс орон бүр хүчин чармайлт гаргах хэрэгтэй тухай нотолсон байдаг” (RECNA, 2015, р. 40). (Хавсралт 1 батлан хамгаалах зардал) (хавсралт 2 цөмийн зэвсгийн тоо)

Товч дүгнэхэд АНУ болон ЗХУ 1962 онд болсон Карибын хямралаас сургамж авч хэрвээ хоёр улсын хооронд зэвсэгт мөргөлдөөн болвол цөмийн дайн руу хөтлөх учраас цөмийн зэвсгийн босоо тархалтыг зогсоож, үе шаттайгаар хорогдуулах арга хэмжээг авч эхэлсэн байна.

### ***Цөмийн энергийг энхийн зорилгоор ашиглах нь***

Зарим физикчдын дурдсанаар 1945 онд хаясан бөмбөг зэвсэг байгаагүй харин хамгийн сайн “туршилт” байсан гэж үздэг. Тухайн үед цөмийн бөмбөгийг дайны үйл явцыг эргүүлэх хүчтэй зэвсэг гэж үзэхээс биш түүний аюулгүй байдлын асуудал, энхийн зорилгоор ашиглах

---

<sup>25</sup> 1972 оны 5 дугаар сарын 26-нд байгуулагдсан гэрээ

<sup>26</sup> SORT (Strategic Offensive Reduction Treaty) буюу Стратегийн давшилтын зэвсэглэлийг хорогдуулах гэрээ

<sup>27</sup> Албан ёсоор Стратегийн давшилтын зэвсэглэлийг цаашид хязгаарал болон хорогдуулах арга хэмжээ гэдэг, шинэ START нь АНУ, ОХУ-ын хооронд байгуулсан Стратегийн давшилтын зэвсэглэлийг хорогдуулах тухай гэрээ болох SORT-ыг залгамжилсан

зэргийг тэр бүр авч үздэггүй байв. Алдагдах эсвэл хууль бусаар хэрэглэх боломжтой талаар хэн ч санаа тавьдаггүй байв. Тухайн үед хэзээ хэрэглэхийг дайны үйл явц, олон улсын нөхцөл байдлаас хамаарч ашиглалтыг цэргийн чанга хараа хяналт мэддэг байв. Цөмийн зэвсэг эзэмших нь чухал байсан ч цаг өнгөрөх тусам аюулгүй байдал түүнээс чухал тавигдаж эхлэв. Цөмийн зэвсэг үйлдвэрлэх, эзэмших нь аюултай байсан ба тохиолдлын осол гарахад яах вэ гэсэн асуудал гарч ирэх болов. Иймээс аюулгүй байдлын үүднээс цөмийн цэнэгтэй хошууг зэвсгээс нь салангид байлгах болов (Reed, 2010, p. 132). Үүний зэрэгцээ цөмийн зэвсгийн бодлогоор зөвлөхийг цэргийнхэнд бус эрдэмтдэд хариуцуулсан ба цөмийн зэвсэг хэрэглэх эрхийг гагцхүү Ерөнхийлөгчийн мэдэлд шилжүүлэв.

1945 оны 11-р сарын 15-нд АНУ, Их Британи, Канадын тэргүүн нар Вашингтон хотноо уулзахдаа “Гурван улсын хооронд цөмийн энергийн талаарх зөвшилцсон тунхаг”-ийг гаргав. Уг тунхагт гурван улс цөмийн энергийг хөнөөх зорилгоор бус гагцхүү “бүх улс орнуудад хэрэглэж болох аюулгүй байдлыг харилцан найдвартай баталгаажуулах арга барилыг бий болгож болох” нөхцөлд харилцан идэвхтэй ажиллах ямар ч улс оронтой энхийн зорилгоор шинжлэх ухааны эх материал солилцохыг хүсэж байгаагаа тусгасан байна (Fisher, 1999).

Үүний дараахан 1945 оны 12-р сарын 27-нд Москвад болсон 3 гүрний гадаад хэргийн сайд нарын уулзалтаар АНУ, Их Британий санал болгосноор цөмийн энерги болон түүнтэй холбоотой материалын талаар гарч буй асуудлуудыг шийдвэрлэх зорилготой НҮБ-ын Цөмийн энергийн комиссыг (НҮБ-ын ЦЭК, UNAEC) байгуулах санал тавьж, ЗХУ санал нэгтгэй хүлээн авав. Гэхдээ энд ч гэсэн хүйтэн дайны уур амьсгал орсон байдаг. Зөвлөлтийн байр суурийн нэг онцлог нь НҮБ-ын ЦЭК-ийг хориг тавих эрхтэй НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн дор байх ёстой гэж үзэж байсан ба шинээр байгуулагдсан ОУАЭА-ийн гол зорилгын нэг нь үзүүлж байгаа цөмийн тусламж эсвэл цөмийн материалын нийлүүлэлт цаашлаад зэвсгийн зорилгоор ашиглагдахгүй байх талаар аюулгүй байдлын баталгааг бий болгох (Article III.A.5); мөн энэ зорилгоор цөмийн аюулгүй байдлын стандартыг тогтоож батлах (Article III.A.6) зэрэг байв (Fisher, 1999). Уг дүрмэнд ЗХУ-д ашиг сонирхолд нь нийцэхгүй гэж үзвэл АЗ дээр хориг тавих эрхтэй байхаар тусгажээ. Чухамдаа Б.Барухын төлөвлөгөө вето буюу хоригийн асуудлыг тойрч гарахыг оролдсон юм.

1946 оны Цөмийн Энергийн Актад цөмийг хэрэглэх цэрэг, иргэний зүйл заалт орсон байдаг. Ингээд 1946 оны 1 сард НҮБ-ын Ерөнхий Ассамблейн анхны чуулганы эхний тогтоолоор НҮБ-ын ЦЭК байгуулагдав. Энэ байгууллагын гол зорилго нь хожмоо ҮДГ-ний үндэс болсон улс орнуудын хяналтаас гадуур байгаа цөмийн энергид хяналт тавих тогтолцоо байхгүй учраас тэдгээрт хяналт тавихад оршиж байв.

АНУ-ын зүгээс өөрийн алхмыг хийж 1946 оны 6-р сарын 13-нд Бернард Барух НҮБ-ын ЦЭК-т түүний нэрээр нэрлэсэн төлөвлөгөөг танилцуулав. Энэхүү төлөвлөгөө нь дэлхийн аюулгүй байдалд аюул учруулж болохуйц аливаа төрлийн цөмийн энергийн үйл ажиллагааг хянах эсвэл эзэмших чиг үүрэг бүхий Олон улсын цөмийн хөгжлийн байгууллага байгуулахыг (ОУЦХБ, IADA) санал болгож байв. 1946 оны 6-р сарын 19-нд Андрей Громыко Зөвлөлтийн байр суурийг илэрхийлж Б.Барухын “зэвсэг хураахаас өмнө эхлээд хяналт тавих” гэсэн санааны өөдөөс юуны өмнө цөмийн зэвсэг үйлдвэрлэх болон хэрэглэх нь хууль бус болохыг заасан улс орнуудыг нэгтгэсэн олон улсын конвенцыг батлаад, одоо байгаа бүх цөмийн зэвсгийг уг конвенци хүчин төгөлдөр болсноос хойш 3 сарын дотор устгах санал дэвшүүлэв. Ингэсэн тохиолдолд л НҮБ-ын ЦЭК цөмийн зэвсгийг үйлдвэрлэхээс урьдчилан сэргийлэх хяналтыг тавьж чадна тэрнээс нааш энэ бүхэн хэрэгжих боломжгүй гэж үзэж байв. Өөрөөр хэлбэл зэвсэгт

хяналт тавихаас өмнө байгаа зэвсгээ устгахаас нааш Баруухын төлөвлөгөө хэрэгжихгүй гэж үзэж байв. Үүний дараа АНУ өөрийн зүгээс дахин нэг алхам хийсэн нь 1946 оны 7-р сарын сүүлчээр АНУ-ын Конгресс МакМахоны хууль (AEA/46)-ийг батлав. Энэ хуулиар “аливаа улсад цөмийн зэвсэгтэй улс орнууд цөмийн энергийг энхийн зорилгоор ашиглах мэдээллийг бодитой аюулгүй байдлын баталгаа гарах хүртэл солилцохгүй байх” тухай заалт орсон ба үүний цаад утга санаа нь АНУ-ын ганцаар давамгайл байдлыг хадгалах зорилготой байв (Fisher, 1999, p. 21). Тухайн үед АНУ дангаараа цөмийн технологи эзэмшиж байсан ба 1949 онд ЗХУ цөмийн туршилт хийх хүртэл цөмийн монопол эрхтэй байв.

1953 оны 12-р сарын 8-нд АНУ-ын Ерөнхийлөгч Дуайт Эйзенхауэр НҮБ-ын ЕА-д цөмийн энергийг энхийн зорилгоор ашиглахыг дэмжиж, цэргийн зорилгоор ашиглахгүй байх талын үйл ажиллагаа явуулах байгууллага байгуулах санал тавьсан байдаг. Тухайн үед АНУ-аас гадна ЗХУ Их Британи хоёр цөмийн зэвсэгтэй болчихсон байв. Д.Эйзенхауэрын энэхүү саналаар Олон улсын атомын энергийн агентлаг байгуулагдаж, энэхүү байгууллага 1978 онд АНУ Д.Эйзенхауэрын “Энхийн төлөөх Атом” хөтөлбөрийг дуусгавар болгосон цөмийн тухай хууль батлагдах хүртэл цөмийн энергийг иргэний зорилгоор ашиглахад олон улсын хамтын ажиллагааг бий болгоход дэмжлэг үзүүлж байв. Тухайн үед Д.Эйзенхауэрын хамгийн их санаа зовоож байсан зүйл бол цөмийн зэвсгийг хэрхэн хийх асуудал нь нууц биш болсонд оршив. Цөмийн технологийг Их Британи, ЗХУ, Канад болон бусад орнууд эзэмшсэн байсан учраас Д.Эйзенхауэр ЗХУ-д цөмийн энергийг энхийн зорилгоор ашиглах нь мөрөөдөл биш, үр шим нь бодитой байгаа талаар итгүүлэхийг оролдож байв. Д.Эйзенхауэрын гол санаа нь цөмийн материалыг цэргийн зориулалттай ашиглахыг хязгаарлах эсвэл бүр устгах арга замыг хайхад байв. Тэрээр “цөмийн зэвсгийг цэргийн мэдлээс гаргах нь хангалтгүй, цөмийн материалыг хэрхэн энхийн зорилгоор ашиглах талаар мэдэх хүмүүсийн мэдэлд өгөх ёстой” гэж байв. Байгуулагдаж буй агентлаг нь цацраг идэвхит болон бусад материалуудыг хадгалж, хамгаалж байх үүрэгтэй байсан юм.

1954 оны 3-р сарын 19-нд АНУ-ын Төрийн Департамент Зөвлөлтийн элчин сайд Георги Зарубинд Д.Эйзенхауэрын агентлаг байгуулах саналыг танилцуулав (Fisher, 1999). Энэ ээдрээтэй нөхцөл байдалд ч цөмийн зэвсэгтэй гүрнүүд байр сууринаасаа ухраагүй. Тэд цөмийн зэвсэгтэй болсон гэдгээрээ бас өндөр хариуцлагатай байх ёстой гэдгээ бага ч гэсэн ухамсарлаж байх ёстой байв. Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд цөмийн энергийн талаар авч хэрэгжүүлж байсан бодлогоо болих бус харин “дэлхий дахинд цөмийн зэвсгийн тархалтыг багасгах” бүх арга замыг эрэлхийлэх зорилгодоо хэрхэн хүрэх талаар бодох хэрэгтэй (Fisher, 1999) болсон. Цөмийн зэвсэгтэй гүрнүүд цөмийн зэвсгийн тархалтыг багасгах нэг алхам нь энхийн зорилгоор ашиглах явдал гэж үзсэн байх талтай. Учир нь цөмийн зэвсэггүй оронд ч гэсэн цөмийн технологийг ашиглах боломжийг олгох нь цааш зэвсгийн зориулалтаар хэрэглэх сэдлийг бууруулснаар энхийн замаар ашиглах нь улс орнуудын хөгжилд их хувь нэмэр оруулах юм. Гэхдээ гол асуудал нь цөмийн үйл ажиллагааг цэргийн зориулалтаар явуулахгүй байхын тулд хяналт тавих нь маргаантай байв. Үндэсний ашиг сонирхолын үүднээс ерөнхийдөө Барууны орнууд, нэн ялангуяа Их Британи, АНУ, Франц, Белги, Португал болон бусад орнууд ОУАЭА-ийг хяналт тавьж болох ч бусдын хэрэгт хөндлөнгөөс оролцоод байхыг хүсэхгүй байв. Харин ЗХУ ОУАЭА-ийг Аюулгүйн Зөвлөлийн шууд удирдлаган дор байлгахыг хүсэж барууны гар хөл болохыг дэмжихгүй байв. Ингэснээр хэрэв Барууны орнууд ОУАЭА дахь давамгайл байдлаа ашиглан ЗХУ-ын эсрэг үйл ажиллагаа явуулах гэж оролдсон тохиолдолд хориг тавих эрхээ эдлэх бодолтой байв. Харин хөгжиж буй орнууд ОУАЭА-ийг НҮБ-тэй нягт холбоотой, ЕА-н хүрээнд байлгахыг хүсэж байв (Fisher, 1999).

Цөмийн тархалтын асуудал ХБНГУ, Франц улс ҮДГ-нд нэгдээгүй цөмийн зэвсэггүй орнуудад цөмийг дахин боловсруулж, баяжуулах технологийг зарах тухай мэдээлэл гарснаар цөмийн зэвсэг улам тархах айдас төрүүлэх болов. Үүний улмаас АНУ, ЗХУ ҮДГ-нээс гадна 1974 онд Москва хотноо уулзаж засгийн газрын цөмийн ханган нийлүүлэгчдийн бүлэг (ЦХНБ)<sup>28</sup> болох цөмийн материал эсвэл тоног төхөөрөмжийг экспортлох зорилготой бүлэг байгуулахаар болов. 1975 онд 15 орны засгийн газрын төлөөлөгчид Лондон хотноо уулзсан ба тэднийг “Лондонгийн клуб” хэмээн нэрлэдэг болсон. 1977 онд гаргасан ЦХНБ-ийн үндсэн хоёр удирдамжинд экспортлогч орнууд технологио шилжүүлэх үндсэн дээр цөмийн зэвсэггүй оронд цөмийн цахилгаан станц (ЦЦС) барих тохиолдолд ОУАЭА-ийн баталгааг авах шаардлагатай ба экспортлогч орон аюултай материалыг шилжүүлэхгүй, дахин боловсруулах, баяжуулах технологийг шилжүүлэхгүй байх хэрэгтэй. ЦХНБ-ээс гаргасан дээрх чиглэлд тухайн цөмийн зэвсэггүй орон ҮДГ-нд орсон эсэхийг хамаардаггүй байв. Зарим ЦХНБ-д байсан орнууд уг удирдамжийг ҮДГ-ний 4-н 2-р зүйлд заасанчлан “нэгдэн орсон бүх талууд цөмийн энергийг энхийн зорилгоор ашиглахын тулд багаж зэмсэг, материал, шинжлэх ухаан, технологийн бүхий л солилцоог хийх боломжтой” гэсэн заалттай зөрчилдөж байна гэж үзэж байв. Энэ асуудал 1980 онд болсон ҮДГ-ний хяналтын бага хуралд нэлээн маргаан дэгдээж байв (Fisher, 1999).

1977 онд Ж.Картер АНУ-ын Ерөнхийлөгч болсныхоо дараа плутонийг иргэний зориулалтаар ашиглахыг эсэргүүцэж байв. Тэрээр плутонийг иргэний зориулалтаар ашигласнаар плутоний зах зээл бий болж энэ нь тэр даруйдаа цөмийн зэвсэг дэлгэрүүлэхэд хүргэнэ гэж болгоомжилж байв. АНУ-ын Конгресийн гишүүдийн олонх нь Ж.Картерийн байр суурийг дэмжиж, 1978 онд Ж.Картерийн болгоомжлолыг тусгасан, плутонийг иргэний зориулалтаар ашиглахыг бараг хорьсон Үл дэлгэрүүлэх хуулийг (P.L. 242) батлав. 1978 оны хууль АНУ-ын хувьд экспортын шинэ нөхцлийг тавьсан байв. Тухайлбал: ОУАЭА-ийн хяналтанд цөмийн бүх материалаа оруулаагүй болон ҮДГ-нд заасан шаардлагыг биелүүлээгүй цөмийн зэвсэггүй ямар ч улсад АНУ цөмийн экспорт хийхгүй, АНУ цөмийн материалаар хангах тохиолдолд ОУАЭА-ийн байнгын хяналтанд байна, ОУАЭА-ийн хяналтнаас гарсан аливаа цөмийн зэвсэггүй орон руу АНУ ямар ч цөмийн материал, тоног төхөөрөмж, цөмийн аюултай технологи экспортлохгүй (Fisher, 1999) гэсэн заалтуудыг оруулсан байдаг. Цөмийг энхийн зорилгоор ашиглах нь хүн төрөлхтний хөгжилд маш их хувь нэмэр оруулах ба зэвсгийн зориулалтаар ашиглахаас урьдчилан сэргийлэхэд тодорхой хэмжээнд нөлөөлсөн гэж үздэг. Тиймээс ҮДГ болон ЦЗБ-үүдийн гэрээнд энхийн зорилгоор ашиглах, тээвэрлэх, туршихыг тодорхой хяналтан дор зөвшөөрсөн байдаг. Өнөөдөр цөмийн энергийг анагаах, ариутгал, эрчим хүч, сансар, шинжлэх ухааны нээлт, хүнс, хөдөө аж ахуйн салбарт өргөнөөр ашиглаж байна.

Товч дүгнэхэд АНУ ганцаараа цөмийн зэвсэгтэй болсон тэр үеэс цөмийн зэвсэгтэй ганц орон байхыг эрмэлзэж байсан ба нэн ялангуяа гол сөргөлдөгч ЗХУ-д энэхүү зэвсгийг эзэмшүүлэхгүй байх талаар арга зам эрэлхийлж байсан байдаг. Гэхдээ АНУ цөмийн технологи эрт орой хэзээ нэгэн цагт дэлхий дахинаа тархахыг мэдэж байсан учраас бусад улс орнуудыг цөмийн зэвсгээр хөөцөлдөхөөс урьдчилан сэргийлэхийн тулд цөмийн технологийг энхийн зорилгоор ашиглах боломжийг бүрдүүлэх нь цөмийн зэвсгээр хөөцөлдөх болон цөмийн зэвсэгтэй орнуудын тоог нэмэхгүй байх арга замуудын нэг гэж үзэж байв. Энэ ч үүднээс одоогоор цөмийн зэвсэггүй байгаа ч “энхийн зорилгоор” хэмээх халхавчаар цөмийн зэвсэг хийх санаа агуулж байгаа улс орнуудыг хянаж, үнэхээр энхийн зорилгоор цөмийн технологийг ашиглах хүсэлтэй байгаа орнуудтай хамтран ажиллах зорилгоор байгуулсан институци нь Олон улсын атомын энергийн агентлаг (ОУАЭА) билээ.

---

<sup>28</sup> Nuclear Suppliers' Group (NSG)

Монгол Улсын хувьд цөмийн энергийг ашиглах асуудал эхлэх шатандаа явж, анагаах ухааны салбарт ОУАЭА-тай цөмийн технологийн талаар хамтран ажиллаж байгаа ба сүүлийн үед шуугиан тариад байгаа асуудал нь цөмийн цахилгаан станцаас гарсан шаарыг Монголд булшлах яриа юм. Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид байх тухай хууль нь цөмийн энергитэй бус цөмийн зэвсэгтэй холбоотой асуудлыг зохицуулах хууль болохыг юуны өмнө анхаарах хэрэгтэй юм. Энэхүү хуулийн 3-р зүйлд “цөмийн зэвсэг” гэдэгт мбүгд зэвсгийн буюу дайны зориулалттай гэсэн асуудлыг оруулсан байдаг. Харин хуулийн 4.1.4-т “цөмийн зэвсгийн гаралтай тусгай ангиллын цацраг идэвхт материал, шаар болон аюултай хог хаягдлыг булшлах буюу устгах”-ыг хориглосон гэсэн заалт байдаг ч эдгээр заалтын 4.1-т “...цөмийн зэвсэгтэй холбогдсон үйлдэл, үйл ажиллагаа” гэсэн байгаа нь энхийн зорилгоор гарган авсан шаарт хамаарахгүй мэт ойлголтыг төрүүлэх магадлалтай юм. Мөн хуулийн 5.2-т “Монгол Улсын хил орчимд хүн ам, байгаль орчны аюулгүй байдалд шууд нөлөөлөх буюу алсдаа сөргөөр нөлөөлж болзошгүй цөмийн шаар, аюултай хог хаягдал булшлах буюу хадгалуулахгүй байх талаар хамтран ажиллах”-аар заасан байна. Учир нь цацраг идэвхит хог хаягдал ганцхан цөмийн цахилгаан станцаас гардаггүй.

Ялангуяа цөмийн зэвсэгтэй гүрнүүд Монгол Улсын аюулгүй байдлын асуудлыг цөмийн зэвсэгтэй холбон ойлгож байгаа. Энэ утгаараа тэд Монгол Улсын зарласан ЦЗАС-ийг дэмжиж байгаа ч дайны бус аливаа зориулалтаар ашиглахад татгалзахгүй юм. Тэр тусмаа Монгол Улсын цөмийн энергийн тухайн хуулийн засгийн газрын бүрэн эрхийн 9.1.8-д цөмийн хаягдал, ашиглагдсан цөмийн түлшийг хүн ам, нийгэм, байгаль орчинд аюулгүй хадгалах урт хугацааны хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ (хууль, 2009), мөн хуулийн Цөмийн энергийн комиссын бүрэн эрхэд 11.1.7-д цөмийн болон цацраг идэвхт хаягдал, цацрагийн үүсгүүрийг улсын хэмжээнд төвлөрүүлэн хадгалах, тээвэрлэх, булшлах үйл ажиллагааг хэрэгжүүлэх гэж заасан байдаг ба үүгээр ч барахгүй 11.2-т цөмийн энергийн комисс нь цөмийн материал, цөмийн болон ашиглагдахгүй болсон цацраг идэвхт хаягдлыг улсын хэмжээнд төвлөрүүлэн хадгалах, тээвэрлэх, булшлах тусгай байгууламжтай байх бөгөөд уг байгууламж нь улсын онц чухал объект байна зэрэг заалтууд нь ард нийтийн дунд цөмийн шаар хаягдлыг Монгол Улсад булшилж болох юм байна гэсэн хардлагыг төрүүлж байгаа нь зүй ёсны юм. Ямарваа нэгэн шаар булшлахгүй нь тодорхой бол ийм төрлийн заалт байх шаардлагагүй юм. Цөмийн энергийн тухай хуулийн 2015 оны нэмэлт өөрчлөлтөөр цацраг идэвхит хаягдал гэдэгт цөмийн төхөөрөмжөөс гарах цацраг идэвхт хаягдлаас бусад төрлийн цөмийн технологийн хэрэглээний хаягдлыг болохыг нарийвчлан заасан байдаг. Мөн Монгол Улсын цөмийн энергийн тухай хуулийн зорилтод Монгол Улсын нутаг дэвсгэрт цацраг идэвхит ашигт малтмал болон цөмийн энергийг энхийн зорилгоор ашиглахтай холбоотой харилцааг зохицуулна гэж байгаа нь гагцхүү Монгол Улсад ашигласан тохиолдолд түүний шаар хаягдлын асуудлыг зохицуулахаар байна гэж үзэж болно.

## Дүгнэлт

1945 онд АНУ анх цөмийн туршил хийсэн үеэс эхлэн цөмийн эрин үе эхэлсэн гэж үздэг. Цөмийн зэвсгийг аюулгүй байдлыг хамгаалах гол арга хэрэгсэл болгохын зэрэгцээ дэлхийн улс орнуудад бодлого, ашиг сонирхолоо тулгахад чухал хэрэгсэл гэдэг утгаар их гүрнүүд болон тэдгээртэй эн зэрэгцэхийг хүссэн улс орнууд цөмийн зэвсгээр хөөцөлдөх болсон байдаг. Хүйтэн дайны үед цөмийн зэвсгийн үүрэг, ач холбогдол дээд цэгтээ хүрч, олон улсын харилцааны дэг журмыг тодорхойлж байсан байдаг. Хэдийгээр хүйтэн дайны дараа энэхүү зэвсгийн ач холбогдол суларсан боловч үндсэндээ 2014 оноос Орос Украинаас Кримиийг тасалж авснаас

эхлэн цөмийн зэвсгийн ач холбогдол дахин нэмэгдэж эхэлсэн ба өнөөдөр аюулгүй байдал дахь цөмийн зэвсгийн асуудлыг улс орнууд улам ихээр ярих болсон байна.

Шинэ Хүйтэн дайн гэх олон улсын харилцааны өнөөгийн нөхцөл байдалд аюулгүй байдлын асуудал улам хүчтэй яригдаж, АНУ-ыг сөрөн гарч ирж байгаа гүрнүүд олон туйлт дэлхийн дэг журмын талаар ярих болсон нь реализмын онолын дэг сургуулийн сэтгэгчид болох Жон Миршаймер, Кеннет Уолц нарын дурьдсанчлан “олон туйлт дэлхийн дэг журам нь хоёр туйлтаас илүү тогтворгүй байх” тул цөмийн зэвсгийн ач холбогдол буурахгүй нь тодорхой байна.

## НОМ ЗҮЙ:

1. Burry Buzan and Lene Hansen. 2015. *The Evolution of International Security Studies*. Cambridge University Press.
2. *Cold War Statesmen Confront the Bomb, Nuclear Diplomacy since 1945*. Oxford. 1999.
3. David Fisher. 1997. *History of the International Atomic Energy Agency: The First Forty Years*. IAEA.
4. J.Enkhsaikhan. 1999. Nuclear-Weapon-Free Status: Concept and Practice, paper presented at the Regional Meeting on "Security Concepts in the Changing World". Ulaanbaatar.
5. J.Enkhsaikhan. 2007. Mongolia and Nuclear Age. *China and Eurasia Forum Quarterly*, Volume 5, No. 3.
6. Kumao Kaneko. 2007. National legislation –an important tool for achieving the objectives of non-nuclearization: Japanese experience. *The Mongolian Journal of International Affairs*, No.14.UB.
7. Masatsugu Matsuo. 2005. *Peace and Conflict Studies: A Theoretical Introduction*. Hiroshima.
8. Michael Hamel-Green. 2007. Increasing Role of Nuclear-weapon-free Zones: Challenges and Opportunities. *The Mongolian Journal of International Affairs*, No.14. UB.
9. Tomas C.Reed. 2010. *The Nuclear Express, A Political history of the Bomb and its proliferation*. Minneapolis.
10. (1968). Цөмийн зэвсэг Үл дэлгэрүүлэх гэрээ.
11. (1976). Ерөнхий Ассемблейн 1976.12.10-ны A/RES/31/70 тоот тогтоолын хавсралт
12. UN resolution A/C.1/33/7, annex
13. UN resolution A/S-10/AC.1/17, annex
14. UN resolution A/S-12/11

Comprehensive study on the Question of Nuclear-Weapon-Free Zones in All its Aspects. United Nations General Assembly, 30<sup>th</sup> Session, Supplement 27/A, UN A/10027/Add.1, 8 October 1975.